

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД



Х.НЯМБААТАР

ШҮҮХИЙН БУС ЖУРМААР ӨР БАРАГДУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна. Үүнд:

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” 32 дугаар тогтоолын 3-т “санхүүгийн гэрээ, хэлцэлд оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж, тэдгээрийн хооронд үүссэн эрхийг хангуулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлбөр авагчийн эрхийг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 24 дүгээр тогтоолын хавсралтын 3.1.8-д Банк, санхүүгийн систем дэх чанаргүй зээлийг шуурхай, зардал багатай шийдвэрлэх хууль, эрх зүйн шинэчлэл хийж, санхүү, эдийн засгийн өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлэхээр заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2021 оны “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 12 дугаар тогтоолын хавсралтын 73-т “Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааны тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх” гэж, мөн оны 75 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар дараах асуудлыг хэлэлцэх асуудал”-д Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааны тухай хуулийн төсөл гэж тус тус тусгажээ.

Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах, эсхүл хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхээр заасны дагуу хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгаанд тус үйл ажиллагааг бие даасан хуулиар зохицуулах шаардлагатай болохыг тодорхойлсон болно.

1.2.Практик шаардлага

1.Монголбанкны мөнгөний нийлүүлэлт 2021 оны 7 дугаар сарын байдлаар 27 их наяд төгрөг байна. Мөн нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл 19.5 их наяд төгрөг

байгаагаас хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 1208.6 тэрбум төгрөг, чанаргүй зээл 1984.5 тэрбум төгрөг байна.¹

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүдийн 2018 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн хамтарсан тушаалаар баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023” болон “Чанаргүй активыг бууруулах стратегийн баримт бичиг”-ийг батлан хэрэгжүүлж байгаа ч хууль, эрх зүйн зохицуулалтад оруулах шаардлагатай өөрчлөлтүүд хийгдэхгүй байгаагаас хэрэгжилт нь хангартгүй, чанаргүй зээлийг шүүхээр шийдвэрлэх явц удаан хугацаанд үргэлжилдгээс барьцаа хөрөнгийн үнэ цэнэ алдагдахын зэрэгцээ бусад гарч буй зардлууд банкны зээлийн хүүг нэмэгдүүлэх нөлөөг үзүүлсээр байна.²

Чанаргүй зээл үүсэхэд банк түүний харилцагч, зээлдэгч нарын хооронд байгуулсан гэрээний шаардах эрхийг шүүхээр баталгаажуулж, үүргийн гүйцэтгэлийг албан журмаар хангах Монгол Улсын иргэний болон шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх хууль тогтоомжийн зохицуулалт нөлөөлж байгааг банк, санхүүгийн байгууллагаын мэргэжилтэн, дотоодын судлаачдаас гадна Олон Улсын Валютын Сан, Европын сэргээн босголтын банк, Дэлхийн банк зэрэг байгууллагаас тогтоож, хууль тогтоомжийг боловсронгуй болгох зөвлөмж гаргасан байdag.

Тухайлбал, Дэлхийн банкнаас жил бүр гаргадаг “Бизнес эрхлэх орчин” 2020 тайлан, Олон Улсын Валютын Сангийн зөвлөмжид гэрээний маргааныг шүүхээр шийдвэрлэх хугацаа удаашралтай, баримт бичгийн бүрдлийг цахимаар хангах боломжгүй, төлбөрийн чадваргүйдлийн зохицуулалт дутмаг, барьцааны шаардлагыг баталгаажуулаагүй, шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт байхгүй байна гэж дүгнэсэн байна.³

2.2020 онд анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо өмнөх оноос 10281 хэрэг буюу 23.7 хувиар өссөн бөгөөд үүнээс банк бус санхүүгийн байгууллагаас олгох зээлтэй холбоотой маргаан 1471 хэргээр буюу 2.3 дахин, банкнаас олгох зээлтэй холбоотой маргаан 1196 хэргээр буюу 69.5 хувиар, зээлийн гэрээтэй холбоотой маргаан 108 хэргээр буюу 1.9 хувиар, хадгаламж зээлийн хоршооноос олгох зээлтэй холбоотой маргаан 105 хэргээр буюу 61.4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.⁴

Түүнчлэн 2021 оны эхний хагас жилийн байдлаар иргэний хэргийн анхан шатны шүүхийн Иргэний хуулиар шийдвэрлэсэн нийт хэргийн 23 хувийг Иргэний хуулийн 281-286 дугаар зүйл дэх зээлийн гэрээний маргаан, 14 хувийг банкнаас олгох, 13 хувийг Банк бус санхүүгийн байгууллагаас олгох зээлийн гэрээний маргаан эзэлж байна.⁵ Мөн шүүхийн шийдвэрээс үзэхэд, зээлийн гэрээний өрийн үлдэгдэл болох 1,100,000 төгрөгийн нэхэмжлэлтэй хэрэг 3 шатны шүүхээр хяналдсан⁶ тохиолдол ч байдаг.

¹ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2021 оны 7 дугаар сар.

² Мөн тэнд.

³ Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэл, Монголбанк, 2020 он, 12 дугаар тал.

⁴ Монгол Улсын шүүхийн 2020 оны тайлан, Шүүхийн ерөнхий зөвлөл

⁵ https://www.judcouncil.mn/site/news_full/11367

⁶ Shuukh.mn, Улсын дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны тогтоол 2019.06.13

Эдгээр тоон мэдээллээс үзэхэд зээлийн гэрээтэй холбоотой маргаан нь Иргэний хэргийн шүүхээр голлон шийдвэрлэгдэж буй хэрэг маргааны нэг бөгөөд шүүхийн ачаалал нэмэгдэх томоохон шалтгаан болж байна. Түүнчлэн шүүхийн ачаалал нэмэгдсэнээр шүүхээс үзүүлэх үйлчилгээг авахад иргэдэд хүндрэл, удаашрал үүсэхээс гадна шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны ачааллыг нэмэгдүүлж, удаашралтай байдал бий болгодог. Нэг шийдвэр гүйцэтгэгчид ногдох жишиг норматив 120-180 гүйцэтгэх хуудас байхаар тогтоосон⁷ хэдий ч бодит байдал дээр нэг шийдвэр гүйцэтгэгч үүнээс ч илүү хэмжээний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хариуцдаг бөгөөд чанаргүй зээлийг шүүхийн журмаар шийдвэрлүүлэхэд дунджаар 6.2 жил шаардагдаж байгаа бол хамгийн бага хугацаа нь 134 хоног, хамгийн их хугацаа нь 6058 хоног буюу 16.6 жил байна.

3.Түүнчлэн зээлдүүлэгч нь хэт өндөр хүйтэй зээлийн гэрээнээс үүдэлтэй маргаанаа шүүхээр шийдвэрлүүлэх хүсэлгүй байдаг тул зээлээ буцаан шаардахдаа дарамтлах, нэр хүндийг гутаах, орон байрны халдашгүй байдалд халдах, цахим орчинд нэр хүндэд нь халдах зэрэг хууль бус арга хэрэгслүүдийг ашигладаг бөгөөд үүнд тавих хяналт, хариуцлагын тогтолцоо байхгүйн улмаас зээлдэгчийн эрхэд зүй бусаар халдахад хүргэж байна.

Иймд дээр дурдсан бодлогын баримт бичигт туссан зорилтыг биелүүлэх, шүүхийн ачааллыг бууруулах, үүргийн гүйцэтгэлийг үр дүнтэйгээр хангах, зээлийн гэрээний маргааныг шүүхийн журмаар шийдвэрлүүлэхэд зарцуулах цаг хугацаа, зардал зэргийг хэмнэх боломжит хувилбарыг хуульчилж, хүний хууль ёсны эрх, эрх чөлөөг хамгаалах үүднээс өр барагдуулахад баримтлах зохих стандарт, журмыг тогтоох хууль, эрх зүйн орчныг бий болгох зайлшгүй шаардлага үүссэн гэж үзэж байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан зохицуулах шаардлагаар анхдагч хуулийн төсөл боловсруулах бөгөөд хуулийн төсөл нь 5 бүлэгтэй байна.

Хуулийн төсөлд дээр дурдсан үндэслэл, шаардлагад тулгуурлан зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тусгана. Үүнд:

1.Нийтлэг үндэслэл;

2.Өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг бүртгэх, тэдгээрийн үйл ажиллагаа;

3.Өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд болон өр төлбөртэй этгээдийн эрх, үүрэг;

4.Өр барагдуулах үйл ажиллагаанд тавих хяналт;

5.Бусад асуудлын талаар тус тус хуулийн төсөлд тусгана.

⁷ Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2017 оны А247, А16, А303 дугаар хамтарсан тушаал.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар дараах эерэг үр дагавар бий болно гэж үзэж байна.

- Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн орчин боловсронгуй болж, сонголт нэмэгдэнэ;

- Өр барагдуулах үйл ажиллагаанд зүй зохистой стандарт тогтож, зээлдэгчийн эрхэд халдахгүй байх нөхцөл бүрдэнэ;

- Иргэд, бизнес эрхлэгчдийн зардал, цаг хугацааг хэмнэх боломж бүрдэнэ;

- Санхүүгийн зах зээлийн хувьд мөнгөний эргэлт удаан хугацаанд түгжигдэхгүй байх, зээлийн хүү буурахад нөлөөлнө;

- Өрийн тохиролцоог дахин уян хатнаар хийх, зээлийн гэрээний үүргийг үр дүнтэй ханггуулах, улмаар шүүхийн ачааллыг бууруулах нөхцөл бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төслийг батлахтай холбогдуулан цаашид шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зээлийн мэдээллийн тухай зэрэг хуулийн төслийг дагалдуулан боловсруулна.

-----оОо-----